

ЧИНГИС ХААНЫ БАЙЛДАН ДАГУУЛЛЫН ГОЛ ЗОРИЛГО ЮУ БАЙСАН БЭ?

*Ж. Заанхүү**

Энэ асуудал өнөөг хүртэл харьцангуй нилээд судлагдсан бөгөөд энэ талаар ихэнх судлаачид эрдэмтэд түрэмгийлэх, тонон дээрэмдэх шинж чанартай байсан гэсэн байр суурь баримталж ирсэн болно. Харин бидний үзэхэд арай өөр агуулгатай болох нь харагдаж байна. Үүнтэй холбоотой дараах хэд хэдэн жишээг авч үзэн харьцуулан дүгнэлт хийж болох юм.

Нэгдүгээрт, Чингис хааны Чань Чунь бумбыг урьсан хоёр дахь захидалд: “Миний гарын дор ирсэн бүхэн надтай хамт, надаас зугтаагч бүхэн миний эсрэг болой. Их бэрхийн эцэст он удтал амар жимэр болохын тулд би цэргийн хүчийг хэрэглэж байна. Дэлхий дахины хамаг амьтны сэтгэл намайг дагаж, миний эрхэнд орсон цагт сая амаржиж би зогсоно. Энэ учир би үл дийлдэх цэргийн дунд үлэмжид сүр жавхланг гаргаж, ямагт цэрэглэж явна” гэж онцлон дурьдсан байх юм¹. Үүнээс үзэхэд Чингис хаан миний гарын дор ирсэн бүхэн буюу Монголын эзэнт гүрэнд орсон бүхэн, түүнээс гадуур ангид хүчин гэж дэлхий дахиныг үндсэнд нь хоёр хуваан үзэж байгаагаа шууд тайлбарласны хамт миний эсрэг хандсан бүхнийг дайсан гэж ч бас шууд хэлээгүй бөгөөд миний эсрэг хүчин гэж үзсэн байна. Түүнчлэн дэлхий дахиныг нэгэн жолоонд оруулах явдал бол их бэрх, он удаан хугацаа шаардах зүйл гэж авч үзжээ. Нөгөө талаар дэлхий дахиныг нэгэн жолоонд оруулах гэж байгаагийн гол зорилго нь амар жимэр, амгалан тайван болгох явдал гэж хэлж байна. Дэлхий дахины хүн ардын сэтгэл санааг өөртөө татах явдлыг чухалд үзэхийн хамт уг асуудлыг шууд дайн түрэмгийллээр шийднэ гэж хэлээгүй байна. Эцэст нь хэлэхэд, дэлхий дахин нэгэн жолоонд буюу Монголын эзэнт гүрний эрхэнд орсон цагт Чингис хаан амар амгалан байх болно гэдгээ хэлсэн байна. Үүний тулд цэргийн шууд сүр жавхааг үзүүлж, цэрэг хэрэглэж байна гэдгээ товч тодорхой илэрхийлсэн байна.

Үүнийг Рашид Ад-Дин “Судрын чуулган” бүтээлийнхээ оршилд тодорхой авч үзсэн нь давхар батлагдаж байна. Тухайлбал, “Учир нь

*Ж. Заанхүү - Цагдаагийн Академийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/

тэр богино хугацаанд дэлхийн олон улсыг эзэлсэн нь өөрийнх нь алсыг харах чадлын нь ач уу, нягтлан боловсруулсан бодлогынх уу, зохион байгуулах гарамгай авьяасынх уу, төгс урьдчилан харсных уу, өргөн далайцынх нь байв уу? Тэрээр өөрийн хүчирхэгээрээ олонхи тэрслүүчүүдийг хядсан ба устгасан, төрөлхийн хэрцгийгээр Фараон² Заххак³ шиг тэдний аль нь ч бардамнан ханхалзаж амьсгаадан хийрхэж “Зөвхөн би л байхаас бус надаас өөр хэн ч байхгүй” гэж өөрийнхөө тухай л бодогдоодог байв. Гэтэл Чингис бол дэлхийг нэг л улс, түүний оршин суугчдыг нэгэн санаатан болгосон. Улсын дэвсгэр нутгийн бөмбөлөгийг нь алан хядагч, төрийг булаагч, хэрцгий догшин байлдан эзлэгчдээс цэвэрлээд өөрийнхөө нэрт төрөл төрөгсөд, өөрийнхөө аугаа их залгамжлагчиддаа түүнийг үлдээжээ” гэжээ⁴.

Хоёрдугаарт, Мөн Чань Чунь бумбатай харилцсан захидалд: “Улсыг засахад хүнд бэрх. Миний сэтгэл хүчнийг их зовоож байнам. Нэгэнт байгуулсан их улс гүрнийг удаан тогтоон барих ямар арга байна” гэсэн⁵ асуулт асуусан байна. Энэ асуултанд Чань Чунь бумба: “Их улсыг засах нь бяцхан жарахайг шарах лугаа адил. Хэт чанга үрвэл мах нь үлдэхгүй унана. Бага шарвал түүхий. Хэт шарвал түлэгдэнэ. Улсыг засах нь энэ лугаа адил. Ямагт хэрсүү хичээнгүй болгоомжтой байх нь чухал хэмээн нэг дэх асуултанд хариулсан бол хоёрдахь асуултанд: “Догшин салхи өдөр турш үргэлжилдэггүй. Аадар бороо ч өдөр турш ордоггүй. Тэнгэр газар ч салхи бороог цагаар захирч чадахгүй байтал хүн яахан өөрийн дураар байж чадах билээ. Аливаа юмс тэнгэрийн тааллаас шалтгаална” гэж хариулсан байна.

Чань Чунь бумбатай уулзаж, Чингис хааны асуусан дээрх хоёр асуулт нь дэлхий дахиныг нэгэн жолоонд оруулах, дэлхий дахинд амар амгалан байдал тогтоох гэсэн зорилготой уялдан гарч ирж байна гэж үзэхээр байна. Нөгөө талаар хэрэв дэлхий дахиныг нэгэн жолоонд оруулах гэж байгаа юм бол түүнийг хэрхэн авч явах тухай асуудал Чингис хааныг ямагт зовоож ирсэн гэдгийг олон жишээ баримтаар тайлбарлаж болно.

Гуравдугаарт, мөн Чань Чунь бумбыг урьсан Чингис хааны захидалд: “Гэвч улс гүрнийг жолоодон засахад эс хүрэлцэх газар байх тул бэрхшээнэ. Гол мөрнийг гатлахын тулд онгоц салыг үйлддэг. Дэлхий дахиныг илбэн засахын тулд эрдэмтэн мэргэдийг урин сонгодог билээ. Хаан миний бие сууринаа сууснаас янагш төр улсыг илбэн засахад сэтгэл хүчийг ихэд сүйтгэх боловч миний шадар түшмэдийн дотор бас ч надад зөвлөх эрдэмтэн мэргэд хараахан илрээгүй байна”⁶ гэж бичсэн

байна. Үүнээс үзэхэд Чингис хаан дэлхий дахиныг илбэн засах гэж үйл ажиллагаа явуулж байгаагаа шууд хэлэхийн хамтаар уг ажлыг олон улсын хэмжээний эрдэмтэн мэргэдийн хүчээр хийж болох юм гэж үзэж байжээ.

Тангуд улсын нэг сайн нумч Чингис хаанд бараалхах бүрдээ биеэ магтан одоо улс иргэнд цэрэг хэрэгтэй бизээ. Елюй Чуцай бичгийн хүн. Түүний хэрэг юу байх вэ? гэдэг байжээ. Үүнийг сонсоод Елюй Чуцай хэлсэн нь: “Нум хийхэд нумч дархан хэрэгтэй биз ээ. Дэлхий дахиныг тогтооход дэлхий дахины засагч урныг үл хэрэглэх болбоос хэрхэн болох вэ? гэж хэлсэн бөгөөд Чингис хаан үүнийг сонсоод машинд баясаж Елюй Чуцайг улам хэрэглэх болов гэж сурвалж бичигт дурьдсан байдаг⁷. Нөгөө талаар энэ ажилд тохирох эрдэмтэн мэргэд нь ямар хэмжээний боловсорсон хүн байх талаар сурвалжилснаа дурдаж, гол шалгуур үзүүлэлтийг ч бас тэмдэглэсэн байх юм. Тухайлбал, “... багш чиний дүр байдал гэгээн тунгалаг, зан суртахуун чигч, үзсэн нь түгээмэл, сонссон нь оновчтой, эрдэм гүн, мэдлэг өргөн, ёсон ариун, зан төлөв эрхэм богд хүний оворыг агуулж эрхэм хувилгаадын суртлыг бүрдүүлжээ. Бас аглаг ойд саатаж аугаа дүрийг далд нууж аршийн их ёсыг бясалгасан агуйн оронд хургасан бэлэгтэн асар олон хэмээмой” гэжээ⁸.

Энд хэдийгээр эрдэмтэн хүний олон шинжийг дурьдсан боловч хэд хэдэн бүлэгт хуваан авч үзэж болох юм. Тухайлбал,

- Зан суртахуун чигч хэмээн үзсэн нь аливаа асуудалд үнэнч, шударга ханддаг, ноён нурууг олж чаддаг тийм шинжийг онцгойлон үзэх нь аргагүй бөгөөд дэлхий дахиныг засан тохинуулахад аль нэг улсын бодлогыг туйлшруулан авч үздэггүй, аль ч улс оронд тохирох улс төрийн бодлого боловсруулах зорилт тавьж байсантай салшгүй холбоотой шинж гэж үзвэл зохино.

- Үзсэн нь түгээмэл, сонссон нь оновчтой, эрдэм гүн, мэдлэг өргөн гэж үзсэн энэ асуудал нь маш нарийн төвөгтэй үйл ажиллагаа учраас хамгийн өргөн мэдлэг шаардана гэж үзэж байжээ.

- Зан төлөв эрхэм гэж заасан нь зан заншил, уламжлалаа сайн мэддэг хэнд ч зөв чиг баримжаа болохуйцаа зөвлөж чадах хүнийг эрхэмлэж байсныг харуулж байна.

- Аршийн их ёсыг бясалгасан, ойд саатан сууж байсан зэргээр тэмдэглэсэн нь хэнээс ч хараат биш, зөвхөн эрдэм номын мөр хөөсөн бясалгагч сэтгэгч зэрэг дээрх шинжүүдийг богд хүний шинж гэж үзсэн байна.

Дөрөвдүгээрт, Чингис хаан нэгэнт улс орнуудыг эзлэн түрэмгийлэх биш, засан тохинуулах зорилгыг агуулж байсан учраас олон иргэдийг алж хядах зорилго тавиагүй болох нь дараах баримтаас харагдаж байна. Тухайлбал, Монголын нууц товчоонд: “Тогочар хан Мэлигийн /Сартуулын Ж.З./ хязгаарын хотуудыг өөрийн дураар сүйтгэж, хан Мэлигийг дайсан болгов. Цээрлэл болгож түүнийг алья гэж хэлсэн боловч, дараа алахаа байж маш буруушаан зэмлэж, цэрэг захирах эрхийг хасав”⁹ гэжээ.

Тавдугаарт, Чингис хаан өөрийн үйл ажиллагаандаа улс орнууд төдийгүй аймаг хоорондын тэмцэлд дайн хийх явдлыг аль болох үгүйсгэж сэтгэл зүйн хувьд дайснаа мохоох замаар өөрийн талд татах бодлого баримталж байсан нь илүү тодорхой харагдаж байна. Энэ талаар найманы Таян хантай байлдах явцад Таян хан: “Бас тэр хойноос нь ирж яваа нүсэр амьтан хэн бэ? гэж асуухад Жамуха өгүүлрүүн:

Хүндэт Өэлүн хатны

Хүний махаар тэжээсэн

Хүчит Хасар гэдэг

Хүү нь тэр мөн гэж хэлж байгаагаас үзэхэд Хасар бол хүний махыг идэж байсан гэж хэн ч ойлгохгүй бөгөөд харин тэр бол хэнд ч дийлдэшгүй хүчтэй тул бууж өгөхөөс өөр аргагүй гэсэн сэтгэл зүйн шинж чанартай болох нь харагдаж байна.

Ийнхүү Чингис хааны цэрэг дайны үйл ажиллагааг судлахдаа түүний дайн байлдаанаас аль болох татгалзаж байсныг ч нарийвчлан судлах шаардлага гарч байна.

ИШЛЭЛ

1. С.Цэрэнбалтав, Ц. Минжин Чингис хааны намтар. Дэд дэвтэр. Албан ёсоор хэвлэгдээгүй хувь. УБ.2002.297-298 дахь тал. Уг захидлыг зохиогч В.Ян Чингис хаан номын 282-283 дахь талаас авснаа дурьдсан боловч хэдэн оны хэвлэл болохыг бичээгүй болно.
2. Коран сударт тулгуурласан дундад зууны шашинтны үзлээр бол Египетийн хаан /Фараон/ нь хэмжээгүй эрхт дураар захирагч хэргийг бөгөөд дарлан зовоогч гэсэнтэй адилтгажээ.
3. Заххак үлгэрт гардаг хаан, араб гаралтай домгийн ёсоор бол Иран орныг олон мянган жилээр боолчлон дарлагч эцгээ алагч шулмасад хууртагдсан, шулам түүнд сэтгэлтэйгээ мэдэгдэх гэж Заххакын мөрийг нь үнссэн учир түүний хоёр мөрнөөс маш том хоёр могой гарчээ. Тэднийг хооллохын тулд Заххак өдөр бүр залуу хүмүүсийг алуулж тэдний тархиар могойг тэжээдэг байжээ.
4. Рашид Ад-Дин Судрын чуулган. Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо. Нэгдүгээр боть. Нэгдүгээр боть. Нэгдүгээр дэвтэр. УБ.1994.28-29 дэ х тал.
5. Ш.Нацагдорж Чингис хааны цадиг УБ.1991. 204 дэх тал. Энд дурьдсан ишлэлийг чухам хаанаас авснаа зохиогч дурьдаагүй байна.
6. Чань Чунь бумбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл. Хятад хэлнээс орчуулсан Н.Ариунгуа. УБ.1997.70 дахь тал
7. Дай Юан улсын бичиг 86 дэх тал
8. Чань Чунь бумбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл. Хятад хэлнээс орчуулсан Н.Ариунгуа. УБ.1997.71 дэх тал
9. Монголын нууц товчоо. УБ.1990. 231-232 дахь тал